Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дотоод аудитор, санхүүгийн хяналт хариуцсан шинжээч, Оюунсүрэн Баярсүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Зорилт 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | | | | | | | |
| 1 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | Зорилтын тоо, шалгуур | Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2024 оны жилийн эцсийн тайлан | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүлсэн байна. | Боловсролын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2024 оны гэрээний үүргийн биелэлтэд үнэлгээ дүгнэлт өгөх ажлын хэсгийг Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/588 тоот тушаалаар баталсан. Боловсролын сайд 2024 онд аймаг нийслэлийн Засаг дарга нартай 5 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг, 4 хавсралтад заасан орон нутаг тус | 1-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрийн үзүүлэлтэд туссан ажлуудыг хийхээр гэрээ байгуулсан. Тухайн жил яамдын бүтцэд өөрчлөлт орсноор шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг орон нутагт хөгжүүлэх чиглэл арга хэмжээнүүд хасагдаж 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 78 үзүүлэлтэд үнэлгээ хийгдсэн. - Орон нутгийн иргэдэд насан турш даа суралцах тэгш боломжийг олгох, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж, насан туршийн боловсролын төвийг бие даасан байр, танхимтай болгох, иргэнд боловсрол нөхөн олгох ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах; - Орон нутагт хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг хангаж ажиллах; - Боловсролын байгууллагын барилга, байгууламжийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орон нутгийн санхүүжилтээс дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; -Боловсролын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган, үр дүнд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өгсөн. | | |
| 2 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах. | Зорилтын тоо, шалгуур | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2024 оны жилийн эцсийн тайлан. | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.6.6-д заасны дагуу Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл болон нэмэлт санхүүжилтийн төсөл, Инженер технологийн дээд боловсрол төсөл, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн хотхоны өргөтгөл төсөл, Атал Бихари Важпайй Мэдээллийн технологи, | 2-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харилцаа холбоо, аутсорсингийн төсөл, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсруулан, цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч ажилласан. Боловсролын сайдын 2025 оны 1/782 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хանган ажиллана. | - | 2024 оруулсан мэдээллийн тоо | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан дүгнэлтийн талаарх мэдээллийг оруулсан байна. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ҮАГ-т 2025 оны 1/2298 тоот албан бичгээр хүргүүлэн ажиллалаа. Боловсролын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ҮАГ-т 2025 оны 2/1082 | 1-р сар, 6-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоот албан бичгээр хүргүүлэв. Сангийн яаманд 2024 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хийсэн үйл ажиллагааны тайлан болон акт, албан шаардлага, зөвлөмжийн тоон тайланг хүргүүлэн ажиллалаа. | | |
| 4 | Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн хэрэгжилтэд холбогдох нэгжүүдтэй хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийсэн байна. | Хамрагдах байгууллагын тоо | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитыг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулсан байна. | Удирдлагын шийдвэрээр 9,10 сард хийхээр хойшлогдсон. | 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 0% |
| 5 | Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн цэцэрлэгийн хоолны зардлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, дотоод аудитыг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт боловсруулах | - | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийх ажлын удирдамж боловсруулсан байна. | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/89 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа. “Ерөнхий боловсролын сургуулийн хоол | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 10 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд ерөнхий хэрэгжилт 83 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх, тэгш боломжоор суралцахуйг дэмжих зэрэг хамтын ажиллагааны төслүүдийн хүрээнд сургуулийн хоолны орчин, хүний нөөц, бодлогын орчинд мэдэгдэхүйц ахиц гарсан байна. Төслийн хүрээнд сургуулиудад хүлэмж байгуулах, хоол зүйн боловсрол олгох, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг дэд бүтцийн дэмжлэг үзүүлж, эдгээр үйл ажиллагааг 83–85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлжээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас яамны Хоол, үйлдвэрлэлийн хэлтэс, Боловролын ерөнхий газарт зөвлөмж | | байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулан ажиллалаа. | | |
| 1.1. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, төсөв, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, аюулгүй байдал, харьяа байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит явуулах, дүгнэлт, зөвлөмж гаргах | | | | | | | |
| 6 | Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх. | Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн | 2024 оны үйл ажиллагааны тайлан | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна. | Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/108 дугаар тушаалын дагуу нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт болон 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж тайланг боловсруулан санал дүгнэлтийг боловсруулсан.<br>Хавсралт: 1 файл | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 7 | Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх. | Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна. | Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажил удирдлагын шийдвэрээр 9,11 дүгээр саруудад хийхээр хойшлогдсон бөгөөд Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн “Удирдамж батлах | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай” А/149 дүгээр тушаалын дагуу Боловсролын үнэлгээний төвийн төсвийн санхүүжилт, хуваарилалт, үр дүн, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан байдал, санхүүгийн үйл ажиллагааны хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг бүртгэлд тусгасан эсэхэд санхүүгийн хяналт шалгалтыг хийсэн.<br>Хавсралт: 2 файл | | байдал: 50% |
| 8 | Түрээсийн сурах бичгийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн | - | - | Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/92 тоот тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, тайланг боловсруулан цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийг Ерөнхий боловсролын газар, Боловсролын ерөнхий газар, Ерөнхий | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсролын сургуулийн захирал нарт өгсөн. Зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний биелэлтийг аймаг, нийслэлийн Боловсролын газраас авч нэгтгэн ажилласан. Боловсролын яамны Дотоод аудитын хорооны 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж ДАХ-ны 05 дугаар тогтоолоор Боловсролын ерөнхий газарт Төрийн болон төрийн бус өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх удирдамж тус бүрд түрээсийн сурах бичгийн эргэн төлөлтийн явцыг хянах талаар тусгах хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн. | | |
| 9 | Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | - | - | - | Удирдлагын шийдвэрээр 9,10 сард хийхээр төлөвлөсөн.<br>Хавсралт: 2 файл | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэсэн байдал: 0% |
| 3.1. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 10 | Яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлнэ. | Хэрэгжилтийн хувь | - | Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан байна. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу дараах санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж ажиллалаа.Үүнд: 1.Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03-00/16 тоот удирдамжийн дагуу Соёл Урлагийн Их Сургуулийн харьяа Дүрслэх урлагийн академийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийв. 2. Иргэн Б.Оюундариас ирүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалтай холбоотой гомдолд хяналт шалгалтыг хийж хариуг албан бичгээр болон утсаар хүргүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 11 | Боловсролын ерөнхий хууль болон түүнийг дагалдан шинээр батлагдсан хуульд тусгагдсан Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хүрээнд батлах журмуудад санал | Хэрэгжилтийн хувь | - | Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хүрээнд батлах журмуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр санал өгч ажилласан байна. | “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ын төсөлд санал боловсруулан 2025 оны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өгөх | | | | 01/1845 тоот албан бичгээр хүргүүлэв. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн талаарх асуудлын бүртгэлтэй танилцаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгийн санхүүжилтийг авсан 205 суралцагчидтай тооцоо нийлж баталгаажуулаагүй 26,856,954,098.46 төгрөгийн зөрчлийг арилгах талаар санал боловсруулан Үндэсний аудитын газарт 2025 оны 1/1722 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>Хавсралт: 5 файл | сар | гүйцэтгэсэн байдал: 100% |
| 12 | Хариуцсан ажлын үндсэн чиг үүргийн дагуу холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах, биелэлтийг тайлагнах; | - | Өмнөх онд ажлын хэсгүүдэд орж ажилласан. | Ажлын хэсэгт орж ажилласан байна. | Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/182 дугаар тушаалын дагуу Ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн үндсэн болон 2023, 2024 оны санхүү, төсвийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажиллаж байна.Боловсролын сайдын 2025 оны 04 | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр сарын 09-ны өдрийн “Удирдамж батлах тухай” А/149 дүгээр тушаалын дагуу Боловсролын үнэлгээний төвийн төсвийн санхүүжилт, хуваарилалт, үр дүн, орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан байдал, санхүүгийн үйл ажиллагааны хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг бүртгэлд тусгасан эсэхэд санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. Мөн Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/108 дугаар тушаалын дагуу нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт болон 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж тайланг боловсруулан санал дүгнэлтийг боловсруулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын | | байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/121, А/123 дугаар тушаалаар Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/21 дүгээр тушаалаар батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлж буй тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсэгт гишүүнээр, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/86 дугаар тушаалаар зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороонд гишүүнээр тус тус орж ажилласан.<br>Хавсралт: 4 файл | | |
| 13 | Баримт бичгийг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь бүрэн бүрдэлтэйгээр архивд хүлээлгэн өгөх; | Баримтын тоо | Баримтыг архивт хүлээлгэн өгсөн. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг архивт хүлээлгэн өгсөн байна. | Яамны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд үүссэн д төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийсэн хяналт шалгалтын тайлан, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн /ахлах/ акт, албан шаардлагыг /боть-2/ архивт хүлээлгэн өгч | 1-р сар, 2-р сар, 3-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллалаа. | | байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Ажлын байрны чиг үүргийн хүрээнд хамаарах хууль, эрх зүйн баримт бичгийг уншиж судлах | Ажлын байрны чиг үүргийн хүрээнд хамаарах хууль, эрх зүйн баримт бичгийг уншиж судлах | - | Хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэхэд холбогдох хуулиудыг судалсан байна. | Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Улсын салбарын дотоод аудитын аргачлал, Санхүүгийн хяналт шалгалтын стандартыг уншин судлан ажиллалаа. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний шинээр батлагдсан хууль, дүрэм журмыг https://legalinfo.mn/mn сайтаас судлан ажлын хэрэгцээнд ашиглан ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Дотоод аудитын чиглэлээр сургалтад хамрагдах | Ажлын байрны чиг үүргийн хүрээнд холбогдох сургалтуудад хамрагдана. | - | Сургалтад хамрагдсан байна. | Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба, Сангийн яам санаачлан зохион байгуулсан “Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй” сэдэвт сургалтад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хамрагдсан. Сургалтаар 1. дотоод аудитын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хорооны талаар 2. Дотоод аудит, хөндлөнгийн аудитын харилцан уялдаа, холбоо, 3.Дотоод аудитын орчин үеийн чиг хандлага, өөрчлөлтийг хамтдаа буюу алдаа, дутагдлыг илрүүлж, хамтдаа сайжруулах 4. Аудит, хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг асуудлуудыг сайжруулах талаар мэдлэг, мэдээллийг авсан болно.<br>Хавсралт: 1 файл | сар, 12-р сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дотоод аудитор, санхүүгийн хяналт хариуцсан шинжээч, Оюунсүрэн Баярсүрэн /................................................./ Огноо: .........................